

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ᠠᠷᠬᠠᠩᠭ᠋ᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠤᠳᠢᠲᠢ ᠶ᠋ᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ

# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН НЭР:** Аймаг, сумын ИТХ-д оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

**АУДИТЫН КОД:** АРА-2020/04/-НА



Цэцэрлэг хот  
2021 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр

Утас: 7033-3141 Цахим хаяг: [ulambayard@audit.gov.mn](mailto:ulambayard@audit.gov.mn)

Аудитын менежер Т.Байгалмаа

Утас: 7033-2680 Цахим хаяг: [baigalmaat@audit.gov.mn](mailto:baigalmaat@audit.gov.mn)

НАБ-ийн ахлах аудитор Б.Азхүү

Цахим хаяг: [azkhuub@audit.gov.mn](mailto:azkhuub@audit.gov.mn)

НАБ-ийн аудитор П.Цэцэгдулам

Цахим хаяг: [tsetsegdulamp@audit.gov.mn](mailto:tsetsegdulamp@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: [www.arkhangai.audit.mn](http://www.arkhangai.audit.mn)



## **1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын Хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2019 оны 5 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаал, Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.” гэж заасны дагуу нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж, баталгаажуулав.

## **2. Аудитын зорилго:**

Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэв.

## **3. Аудитын хамарсан хүрээ:**

Аудитад аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудитаар баталгаажуулсан сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримт материалыг хамрууллаа.

## **4. Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхэд Монгол улсын стандарт: Төрийн аудит MNS6817:2020, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын 2020.10.14-ний өдрийн А/21 дугаар тушаалаар баталсан “Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг мэдээлэх, танилцуулах журам”-ыг үндэслэн нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчээс лавлагаа, тодруулга авах зэрэг арга зүйг ашиглалаа.

## **5. Үндсэн мэдээлэл:**

Архангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор Аймгийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг 25 тойрог, 39 мандат, сумд 101 хороо, 433 мандаттай байхаар тус тус баталсан байна.

Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн 126-н тойрогт 3 нам, **950**



нэр дэвшигч оролцсон байна. Үүнд:

№	Намын нэр	Нийт нэр дэвшигчид	Аймгийн ИТХ-д нэр дэвшигчид	Сумын ИТХ-д нэр дэвшигчид
1	Аймгийн Монгол ардын нам	472	39	433
2	Аймгийн Ардчилсан нам	472	39	433
3	Аймгийн Монгол ардын хувьсгалт нам	5	3	2
4	Бие даан нэр дэвшигч	1	1	
	<b>Нийт дүн</b>	<b>950</b>	<b>82</b>	<b>868</b>

## 6. Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр удирдаж, аудитын менежер Т.Байгалмаа үе шатны хяналтыг хэрэгжүүлэн, Ахлах аудитор Б. Азхүү, аудитор П. Цэцэгдулам нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв. Аудитын тайланг Тэргүүлэх аудиторын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/01 тоот тушаалаар баталгаажууллаа.

Аудитын багийн зүгээс зардлын тайланг хянах явцад Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон намуудад зардлын тайланг хуулийн хугацаанд ирүүлэх талаар удаа дараа сануулж, хөл хорионы үед сонгуулийн зардлын тайланг хуулийн хугацаанаас 15 хоногоор хойшлуулан цахимаар болон цаасаар хүлээн авч ажиллалаа.

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд 950 нэр дэвшигч бүртгүүлснээс 21 нэр дэвшигч аймаг, сумын ИТХ-д давхар нэр дэвшсэн тул давхардлыг (950-21) тооцоход тайлан ирүүлэх нэр дэвшигч 929 байгаа бөгөөд үүнээс Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 “*Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.*” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа 707 нэр дэвшигч ирүүлснээс 205 нэр дэвшигчийн тайлан хувийн аудитын компаниас болж хугацаа хоцорсон, 279 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд гүйлгээ хийгдээгүй “Х” тайлан гаргасан байна.

Харин **222** нэр дэвшигч тайлангаа ирүүлээгүй байна. Үүнээс **59** нэр дэвшигч нь данс нээлгэсэн гэж мэдээлсэн ч тайлан гаргаагүй, үлдэх **163** нэр дэвшигч нь АНСДИТХСТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.2.“*Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ.*” гэсэн заалтын дагуу сонгуулийн зардлын данс нээлгээгүй байна.



Сонгуулийн зардлын тайланг хянахад **428** нэр дэвшигчийн дансанд 250,306.9 мянган төгрөгийн орлого төвлөрч, сонгуулийн үйл ажиллагааны зардалд 249,206.3 мянган төгрөг зарцуулан, харилцах дансанд 1,100.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/15 дугаар тушаалаар Аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээг тухайн тойргоос хамааран 1,700.0 мянган төгрөгөөс 24,500.0 мянган төгрөгийн хооронд тогтоосон зардлын дээд хэмжээг хэтрүүлэн зарцуулсан нэр дэвшигч байхгүй байна.

• **Намын сонгуулийн зардлын дансны орлогын талаар:**

Аймаг, нийслэл сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалтыг хэрэгжүүлэн МАН-ын аймаг, сумын 20 -н хороо сонгуулийн зардлын данс нээлгэснээс хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтын дагуу 9-н сумын МАН-ын хороо зардлын тайланг аудитын компаниар баталгаажуулж, дүгнэлт гаргуулан ирүүлсэн байна.

Хүснэгт 1. Сонгуулийн зардлын тайлан ирүүлсэн улс төрийн нам

№	Тайлан ирүүлсэн намын нэр	аудитлагдсан зардлын тайлан
1	Архангай аймгийн ӨндөрУлаан сумын МАН	1
2	Архангай аймгийн Хангай сумын МАН	1
3	Архангай аймгийн Эрдэнэмандал сумын МАН	1
4	Архангай аймгийн Булган сумын МАН	1
5	Архангай аймгийн Чулуут сумын МАН	1
6	Архангай аймгийн Цэцэрлэг сумын МАН	1
7	Архангай аймгийн Ихтамир сумын МАН	1
8	Архангай аймгийн Хашаат сумын МАН	1
9	Архангай аймгийн Өлзийт сумын МАН	1
	дүн	9

Орон нутгийн сонгуульд оролцсон аймгийн Ардчилсан намын аймаг, сумдын намын хороод сонгуулийн зардлын данс нээлгээгүй, тайлан ирүүлээгүй, Монгол ардын намын аймаг болон 10 сумдын намын хороод тайлан ирүүлээгүй байна.

Зардлын тайлан ирүүлсэн улс төрийн намд 6 иргэнээс 3,606.0 мянган төгрөгийн хандив өгснөөс хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалтын дагуу нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 2 иргэний 2,280.0 мянган төгрөгийн хандив байна.

Хүснэгт 2. Улс төрийн намд иргэдээс өгсөн хандив

№	Намын нэр	Хуулийн дагуу 1.0 сая төгрөгөөс дээш хандив өгсөн иргэний нэр	Мөнгөн хандивын дүн / мян.төг/
1	Архангай аймгийн Өндөр Улаан сумын МАН	Солио	1,280.0
2	Архангай аймгийн Эрдэнэмандал сумын	А. Цогцэцэг	1,000.0



МАН		
<b>МӨНГӨН ХАНДИВЫН НИЙТ ДҮН</b>		2,280.0

- **Намын сонгуулийн зардлын дансны зарцуулалтын талаар:**

Аймгийн 9-н сумын МАН-ын хороод сонгуулийн зардлын дансанд төвлөрсөн 3,606.0 мянган төгрөгийг сонгуулийн үйл ажиллагаанд бүрэн зарцуулсан байна.

- **Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны орлогын талаар:**

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-д "Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ" гэсэн заалтын хүрээнд сонгуульд оролцсон нийт нэр дэвшигчдээс өөрсдийнх нь гаргаж ирүүлсэн дансны жагсаалтаар 766 нэр дэвшигч сонгуулийн зардлын данс нээлгэсэн, харин 163 нэр дэвшигч зардлын **данс нээлгээгүй** байлаа.

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд нийт 250,306.9 мянган төгрөгийн мөнгөн орлого төвлөрсөн байна. Үүнд:

ОРЛОГЫН ТӨРӨЛ	ОРЛОГО /мян.төг/			НИЙТ ДҮН
	Тоо	Мөнгөн	Мөнгөн бус	
Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	2	5,000.0	-	5,000.0
Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө		73,264.8	-	73,264.8
Хуулийн этгээдийн хандив	6	24,720.0	-	24,720.0
Иргэний хандив	641	147,322.1	-	147,322.1
<b>ДҮН</b>		<b>250,306.9</b>	-	<b>250,306.9</b>

Хүснэгтээс харахад нэр дэвшигчдийн орлогын 68.7 хувь буюу 172,042.1 мянган төгрөг нь иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив байна. Үүний дотор хуулийн дагуу мэдээлэх нэг сая ба түүнээс дээш төгрөгийн 43 иргэний 55,075.0 мянган төгрөг, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 4 хуулийн этгээдийн 24,520.0 мянган төгрөгийн хандив байна. /хандивын жагсаалтыг хавсралт- № 1/

- **Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны зарлагын талаар:**

Нэр дэвшигчид сонгуулийн зардалд 231,964.1 мянган төгрөг, бусад зардалд 17,242.2 мянган төгрөг нийт 249,206.3 мянган төгрөгийг сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулжээ. Үүнд:

ЗАРДЛЫН АНГИЛАЛ		Мөнгөн дүн /мянган төгрөг/
<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>249,206.3</b>
2.1	Сонгуулийн зардлын дүн	231,964.1



2.1.1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	37,423.1
2.1.2	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт, самбар, дэлгэц байрлуулах зардал	182.0
2.1.3	Намын далбааг гудамж, талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	-
2.1.4	Сонгогчтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	50.0
2.1.5	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	190,528.0
2.1.6	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	-
2.1.7	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	3,781.0
2.1.8	цахим орчин ашиглах зардал	-
<b>2.2</b>	<b>Бусад зардлын дүн</b>	<b>17,242.2</b>

Хүснэгтээс харахад нийт зардлын 15.0 хувийг сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах зардал, 76.5 хувийг сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал, 6.9 хувийг бусад зардал, 1.5 хувийг өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал, 0.1 хувийг нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт, самбар, дэлгэц байрлуулах зардал, 0.02 хувийг сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардалд тус тус зарцуулсан байна.

- **Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:**

Сонгуулийн зардлын тайланг хянахад нийт **8,146.2** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлж зарцуулаагүй 7,398.8 мянган төгрөг
- Зардлын дансаар дамжуулаагүй бэлнээр зарцуулсан 747.4 мянган төгрөг,
- Сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй 222 нэр дэвшигч байгаагийн 163 нь сонгуулийн зардлын дансыг хуулийн дагуу нээлгээгүй байна.
- Аймгийн МАН, АН-ын хороо сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй үүнээс АН-ын хороо сонгуулийн зардлын дансыг хуулийн дагуу нээлгээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5-д *"Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ."* гэж заасны дагуу нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны хуулгыг Төрийн банк хугацаа хоцроосон байна.



- **Аудитын дүгнэлт**

- ✚ Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон 222 нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан, аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан баталгаажиж ирээгүйгээс 163 нь данс нээлгээгүй байна.
- ✚ Аймгийн МАН, АН-ын хороо сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй үүнээс АН-ын хороо сонгуулийн зардлын дансыг хуулийн дагуу нээлгээгүй байна.
- ✚ Нэр дэвшигчдэд 1 сая ба түүнээс дээш хандив өгсөн 43 иргэн, 2 сая ба түүнээс дээш хандив өгсөн 4 хуулийн этгээд байна.
- ✚ Аймаг, сумдын сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид нь сонгуулийн зардлын данс нээх, орлогыг хуулийн дагуу төвлөрүүлсэн байх, зардлын тайланг аудитын компаниар дүгнэлт гаргуулан ирүүлэх зэрэг хууль эрх зүйн мэдлэг дутмагаас сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

- **Зөвлөмж**

**Аймгийн Намуудын хороонд:**

Аймаг, сумдын ИТХ-ын ээлжит сонгуульд нэр дэвшигчид сонгуулийн зардлын данс нээлгэж, тухайн дансаар зарцуулалтыг тайлагнаж, аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулах, хуулийн хугацааг баримтлах зэрэг алдаа зөрчлүүдийг гаргасан нь хууль эрх зүйн ойлголт хангалтгүй байгааг харуулж байгаа тул дараагийн сонгуульд анхаарч, сонгуулийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3 дахь заалтын дагуу гарсан зөрчлийг холбогдох байгууллагад хүргүүлэх.

**Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст:**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 50.2 дахь заалтын дагуу сонгуулийн зардлын дансыг нээлгээгүй, 56.3 дахь заалтын дагуу сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй МАН, АН болон 222 нэр дэвшигчдэд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах.